

10 сарын цаг үеийн мэдээ

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Ерөнхий боловсрол

10-р сарын 07-ны өдөр нийт багш нар хуралдаж сургуулийн зорилго зорилт, энэ хичээлийн жилд суралцагчдын сурлагын хоцрогдолыг хэрхэн нөхөх, арилгах, ямар үйл ажиллагаа зохион байгуулах талаар хэлэлцүүлэг зохион байгуулж багш бүрийн санал бодлыг сонсож ажилласан.

Монгол Улсын Орчин цагийн боловсрол, шинжлэх ухааны салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан салбартаа олон жил үр бүтээлтэй ажиллан ажил хөдөлмөрөөрөө тэргүүлсэн багш, ажилчдыг шагнаж урамшууллаа. Боловсролын тэргүүний ажилтан цол тэмдэгээр сургалтын менежер Н.Хонгорзул, БШУЯ-ны "Жуух бичиг"-ээр У. Ганболд, аймгийн ЗД-ын жуух бичгээр Л.Ариунболд, "Баярын бичиг"-ээр Г.Алтантүлхүүр, Х.Эрдэнэбаатар, аймгийн ЗД-ын "Хүндэт тэмдэг"-ээр багш Ш.Пүрэвдорж, сумын ЗД-ын "Хүндэт өргөмжлөл"-өөр багш Л.Доржханд, Л.Болормаа, сумын ИТХ-ын "Хүндэт өргөмжлөл"- өөр багш С.Энхжаргал нар шагнагдлаа.

Мөн манай байгууллагатай хамтран ажилладаг" ББТБ ХХК" Ц.Тулга захиралтай "Хишиг" дэлгүүрээс хичээл сургалтын үйл ажиллагаанд хэрэглэх 32 инчийн өнгөт телевизор гардуулан өглөө.

ХҮҮХЭД -ХӨГЖИЛ-ХАМГААЛАЛ:

"Хөөрхөн Зүрх" ТББ-аас 10-р сарын 11-ний ОУ-ын Охидын эрхийн өдрийг тохиолдуулан 10 сарын 10-ны 14:30-16:00 цагийн хооронд "Охидын эрхийн өдөр ба Хүчирхэг Охид" онлайн вебинарыг "Сургуулийн орчинд дахь охидын эрхийн асуудал", "Хувийн орон зай", "Хүчирхийллээс сэргийлэх нь","Өөрийгөө хайрлахуй" зэрэг сонирхолтой сэдвээр зохион байгуулахад нийт сургуулийн 35 охид хамрагдлаа.

Монголын багш нарын 55 -дахь өдрийг тохиолдуулан суралцагчдад бие биенээ болон багшийг хүндэтгэх, багш мэргэжлээр бахархах үзлийг төлөвшүүлэх, мэргэжлээ сонгох арга зүйд суралцах зорилгоор "БАГШ БОЛОХ САЙХАН" арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

- Багш болох 9-р ангийн сурагчид мэргэжлийн багш нартайгаа уулзаж, хичээл заах арга зүйн зөвлөгөө авч, хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан ажилласан.
- "Багш болох сайхан" хичээл үйл ажиллагааны нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан.
- 08:00 цагаас хичээл үйл ажиллагааны цаг эхэлсэн.
- 11:45 цагаас хичээл үйл ажиллагаанд оролцсон бүх сурагчид сэтгэгдэлээ илэрхийлэх "Дурсамж" ярилцлагыг зохион байгуулсан. - Коронавирус болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамтарсан багийн урьдчилан сэргийлэх зөвлөмж гарын авлагыг нийт 50 ш боловсруулан гаргаж айл өрх бүрээр мэдээлэл өгч ажилласан. Дэлхийн гар угаах өдрийг угтан Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд СӨБ болон ЕБС-ийн суралцагчдын дунд 3 насны ангилалаар дараах сэдвийн хүрээнд гар зургийн уралдааныг 2021.10.12-15-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уралдаанд нийт
- СӨБ -ын 3-5 насны ангилалд 10 бүтээл

- ЕБС-ийн 2-5-р ангийн төрөлд 35 бүтээл, 6-9-р ангийн төрөлд 6 бүтээл нийт 41 бүтээл ирсэнээс хамтарсан багийн гишүүд хамтран шалгаруулалт хийж ажилласан. **ТАНДАЛТЫН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

Тандалтын баг нь өдөр бүрийн халдварын мэдээг БСУГ-т 15 цагт өгч ажиллаж байна. Тандалтын багаас гаргасан хуваарийн дагуу өдөр бүр ажилчид анги танхим, хоолны заал, багш нарын өрөө, номын сан, гадна дотно орчинд ариутгал халдваргүйжилтийг 1, 3 дахь өдрүүдэд хийж, өдөр бүр 17 цагаас их цэвэрлэгээ хийн ажиллаж байна.

БШУЯ-наас хэрэгжүүлж буй халдварын эрсдэлээс сэргийлэх, тандалт хийх, хариу арга хэмжээ авах ажлын хүрээнд “Боловсролын салбарын мэдээллийн систем” ашиглан багш, ажилчид, сурагчдын биеийн байдлыг бүртгэж QR кодоор сургууль руу нэвтрэх ажлыг өглөө бүр амжилттай хийж гүйцэтгэж байна.

Уралдааны шагналд нийт 131000 төгрөгийг хамтарсан багийн төсөвөөс зарцуулсан болно

- Архины хамааралтай болон хүүхдүүд нь айлд сууж буй өрхийн гишүүдтэй уулзалт ярилцлага хийж санал бодлыг нь сонсож ажилласан.

- 1-р багийн хөдөөний гэртээ байгаа Бага насны нийт 35 хүүхдийг витаминжуулах, мөн ахмад настангуудад гарын бэлэг түгээх ажлыг давхар гүйцэтгэсэн. Проперти" ХХК Улсын комисс бүрэлдэхүүн аймгийн Засаг даргын 2021 оны 10 сарын 08 өдрийн А/575 тоот захирамжийн дагуу ажиллаж комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр 50 ортой хүүхдийн дотуур байрыг байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэлээ. Хөрөнгө оруулалт: Улсын төсөв 694,3 сая төгрөг, Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч: "Ай Ди Си байлаа. **Сургуулийн өмнөх боловсрол**

БШУЯ, ЭМЯ-ны хамтран А\292, А\525 тоот түр журмын дагуу коронавирусын цар тахлын үед ажиллах халдвар хамгааллыг мөрдөн, хүүхдэд олгох хөгжил төлөвшлийг олгох орчны нөхцлийг сайжруулах зэргээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд

1. Сургалт хүмүүжлийн ажил
2. Эрүүл ахуй халдвар хамгаалал
3. Бүтээлч ажил чиглэлээр тайланг бичлээ.

Бичиг хэргийн ажлыг цаг тухай бүрт нь хийж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрхлэгчийн тушаал-А-3 Б-26, Ирсэн бичиг- 46, Өргөдөл-4, явсан бичиг-15, хурлын тэмдэглэл-14 байна. Сургалт үйл ажиллагаа

Бүлгийн багш нар 10 сарын “Танхимын болон зайн” сургалтын төлөвлөтийг боловсруулан өдөр тутмын сургалт үйл ажиллагаа болон зайн сургалтын жишиг даалгаврыг бэлтгэн хүүхдүүдэд хүргэж байна.

Ковид цар тахлаас үүдэн ойрын хавьтал болсон, эцэг эхийн хүсэлтээр зайн сургалтад шилжсэн хүүхдэд “Багшийн заавраар жишиг даалгавар 1-3” 34ш материалыг хүргээд байна.

Бүлгийн багш нар “Хөгжмийн хэмнэл”, “Шигтгэмэл”, “Хөгжимт хөдөлгөөн” зэрэг дугуйланг хичээллүүлэн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. дугуйланд нийт 40 хүүхэд хамрагдаж байна.

Бүлгийн багш нар болон туслах багш нар хамтран хамтын хичээлийн туршилт танин мэдэхүй болон хөгжөөн баясах үйл ажиллагаагаар хэлэлцүүлэгт хэлбэрээр зохион байгуулж багш

ажлын байран дээрээ хөгжих, заах арга барил, эвдүй, хамтран ажиллах чадвараа дээшлүүлсэн.

4-5 настай хүүхэд бүрийг 18 чадвартай хяналтын хуудсаар үнэлж судалгааг нэгтгэн ажилласан. ЕБС- тай хамтран “Хөдөөгийн бага насны хүүхдийг сургуульд сайн бэлтгэж, амжилттай суралцах, боломж олгох” төслийн хүрээнд 5 настай хүүхдэд зориулсан сургалтын 12 төрлийн 277.400 төгрөгний хэрэглэгдэхүүн гарын авлагыг хүлээн авч, хувилбарт хамрагдаж байгаа 6 хүүхдэд “ 5 настай хүүхдийг сургуульд бэлтгэх дасгал ажлын дэвтэр, зөвлөмж” хичээлийн хэрэгсэлтэй багцыг өгч ажилласан. ЕБС-ийн багцыг 5 хүүхдэд, СӨБ-ын багцыг 7 хүүхдэд сумын хамтарсан багтай хамтран тараасан.

ГБХЗГ, Боловсролын газар хамтран асрамж халамжийн нэгдсэн холбооны тэргүүн Д.Ундраа багшийн “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал-Бүлгийн багшийн үүрэг оролцоо” сэдэвт сургалтад багш, туслах багш нарын хамт хамрагдаж, мэдлэг мэдээлэл олж авсан. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Бяцхан уншигч” шүлгийн уралдаанд 5 төрлийн шүлгээр 26 хүүхэд өрсөлдөж 1,2,3-р байрыг шалгаруулсан.

Сумын хамтарсан багаас Дэлхийн гар угаах өдөрлөгт зориулан зохион байгуулсан “Гар угаах ач холбогдол” сэдэвт гар зургийн уралдааныг зарлаж 10 хүүхэд оролцож эхний шилдэг зургууд шалгарсан. Уралдаанд оролцсон хүүхдүүдэд 45000 төгрөгний үнэ бүхий зүйлээр урамшуулсан. Эрүүл ахуй халдвар хамгаалал

Амны хөндий үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд цэцэрлэгийн 62 хүүхдийн шүдний өвчлөлийг үзэж, эцэг эхэд өвчлөлийн талаарх мэдээллийг өгсөн. Мөн шүдийг арчлан хамгаалах зөвлөмжийг хүргэсэн.

Бэлтгэл бүлэг нь ангийн дотоод группээрээ дамжуулан “Хичээлийн хэрэглэлтэй зөв харьцах” аргачлал буюу харандаа зөв барих, бийрээр хэрхэн зураг зурах вэ? талаар контентоор хүргэсэн.

Цэцэрлэгийн 4-5 настай хүүхдүүдийн “Гэр-цэцэрлэг-гэр” маршрутыг зуруулснаар хүүхэд хамгаалал- эрсдлийг бууруулах ажил болсон.

Бүлгийн эцэг эхчүүдээр цэцэрлэгийн болон багш ажилчдыг үнэлэх зорилгоор эцэг эхээс сэтгэл ханамжийн судалгааг авч 40 эцэг эх хамрагдсан. Судалгаа дүгнэлтийг цаашид ажиллах ажлын чиглэл болгосон.

. Хөөрхөн шар шувуу сургалт судалгааны төвийн захирал Г.Төмөрзаяагийн бэлтгэсэн “таны хүүхэд 5 настай юу? Сэдэвтэй насны онцлог, хөгжил төлөвшлийг танилцуулсан мэдээллийг бүлгийн группээр дамжуулан эцэг эхчүүдэд хүргэсэн.

Хүүхэд бүрийг хүлээн авах, өдөр унтаж боссоны дараа биеийн халууныг үзэж тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.

Хүүхдүүдийн дархлааг дэмжих зорилгоор нийт 40 хүүхдийг С витаминаар витаминжуулсан.

Гэрээт ААН байгууллагаас хүнсний шинжилгээний бичгүүдийг авч ажил хэрэгтээ мөрдлөг болгон ажиллаж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 08-р сарын 19-ны өдрийн А/292, А/525 тоот тушаалаар батлагдсан түр журмыг ажил хэрэгтээ мөрдлөг болгон ажиллаж байна.

Японы хүүхдийг ивээх Сангаас 154 ширхэг зурагт ном, 12 ширхэг тоглоомын хамт ирсэнийг номыг кодлон байгууллагын номын өргөөг хариуцсан багш П.Оюунтөгсд хүлээлгэн өгсөн.

Цэцэрлэгийн хүүхдийн дархлааг дэмжин 1-р багийн иргэн Лутбаяр, С.Улаанхүү, У.Сүхболдын гэр бүлээс өгсөн сүү, тараг, цагааг орлогодон авч хүүхдүүдэд өдөрлөгийн дагуу хүргэсэн.

ХАБЭА сургалтад “Бодит үнэлэмж” сургалтын төвд хамрагдан шалгалтаа өгч амжилттай төгсөж СЕРТИФИКАТ –аа авсан.

Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлөлт, хяналт-шинжилгээ үнэлгээний сургалтад цахимаар хамрагдан шалгалтаа амжилттай өгч “ГЭРЧИЛГЭЭ” –гээ хүлээн авсан. ЗДТГ-аас зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээнд хамрагдацгаая уриалгад нэгдэн байгууллага хамт олноороо гадна их цэвэрлэгээг хийж гүйцэтгэсэн.

БШУЯСайдын тушаалаар өглөө хүүхэд хүлээн авахдаа QR код уншуулан цэцэрлэгт нэвтрүүлж байна.

Бүтээлч ажил

Бүтээлч ажлын хүрээнд хүүхдийн хөгжмийн мэдрэмж, хэмнэлийг хөгжүүлэх зорилгоор ангидаа даралтат хөгжим-5ш, бөмбөр-7ш, шагшуур-15ш-ийг авч нийт 270.000 төгрөгийн зарцуулсан.

Байгууллагын багш ажилчид тус бүр 3-н төрлийн тасалгааны цэцгийг бүрдүүлэн цэцэгжүүлсэн.

Бүлэгт 2 цаг тутамд ангид чийгтэй цэвэрлэгээ болон агааржуулалтыг хийж суралцагчдыг өглөө, өдөр, орой 3-н удаагийн давтамжтайгаар амыг зайлж хэвшүүлсэн.

7 хоног бүрийн цагаан хэрэглэлийг угааж сольдог ба гудас хөнжлийг 5 хоногт 1 удаа салхинд гаргаж хэвшсэн Өөрөө судлан мэдлэг чадвараа дээшлүүлэн сурч авсан мэдлэгтээ тулгуурлан байгууллагын анги танхим, өрөө тасалгааны хаягжуулалтыг шинэчилэн монгол бичгээр хийж гарган байршуулсан. Мөн ёс зүйн булан, дотоод хяналтын, шилэн данс, ил тодын самбаруудад монгол бичгээр хаягжуулалт хийсэн.

10 сарын ээлжинд гарсан дараалал 16 цагаар 6 удаа 8 цагаар 4 удаа 24 цагаар гарсан ба гарах хугацаандаа нүүрсээ тогтмол шигшиж зуухны градусыг тогтмол хянаж ажилласан

Эрүүл мэндийн чиглэлээр

Үндсэн үзүүлэлтүүд:

- ☐ Нийт үзлэг-154
- ☐ Урьдчилан сэргийлэх-86
- ☐ Артерийн гипертензин эрт илрүүлэг-65
- ☐ Чихрийн шижин эрт илрүүлэг-65
- ☐ Жирэмсний хяналтанд хамрагдсан-0
- ☐ Жинэлсэн хүүхдийн тоо-18
- ☐ Эмнэлэгт хэвтсэн-53
- ☐ Холын дуудлага-12
- ☐ Төвийн дуудлага-46

Сэргээн засах эмчилгээ:

Сэргээн засах эмчилгээ том 1 хүнд, хүүхэд 1 хийсэн.

- Нил улаан туяа-1 том хүн
- Зөөлөн бариа -2 том хүн

Дархлаажуулалт

0-2 насны 30 хүүхдэд товллын дархлаажуулалт хийсэн.

2-11 насны 185 хүүхдийг томуугийн эсрэг дархлаажуулалтанд хамруулсан

Сургалт сурталчилгаа

- Дэлхийн гар угаах өдрийг тохиолдуулан 3-5нас,2-5анги, 6-9ангийн сурагчдийн дунд сумын хамтарсан багтай хамтран гар зургийн уралдаан зохион байгуулсан.
- Цахим хаягаар гар угаах дадал хэвшлийн талаар 1видео, 8төрлийн шторк хүргэсэн.

Сумын хамтарсан багтай хамтран 2,3-р багийн нийт-24 өрхөөр явж хамтарсан багийн үйл ажиллагааг танилцуулан,ковид-19 халдвараас сэргийлэх 30ш зөвлөгөө зөвлөмж тарааж, 15 хүүхдийг витаминжуулалтанд хамруулсан

Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлж

2021,09,04 ковид-19н халдвар дахин бүртгэгдэж нийт тохиолдол 2021,10,20-ны байдлаар 158 тохиолдол бүртгэгдсэн байна.

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа-23

Гэрийн эмчилгээ-7

Эдгэрсэн-124 хүн байна.

Гэрийн эмчилгээний иргэдийн эмийг эмийн сангаас авч багцлан иргэдэд хүргэн өгч өдөр бүр утсаар холбогдон биеийн байдлыг асууж хяналт хийж АОК,МХГ,ЭМГ-т илтгэх хуудсаар хүргүүлж байна.

- Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын судалгааг гаргаж иргэдтэй холбогдож заавар зөвлөмж өгч, ойрын хавьтлыг програмд шивэн оруулж байна.
- Ойрын хавьтлын иргэдийг өдөр бүр шинж тэмдгийн болон хяналтын мэдээг авч бидэнд хүргүүлж түүнийг нэгтгэн АОК,МХГ,АЭМГ-т илтгэх хуудсаар хүргүүлж байна.
- Өдөр бүр нөхцөл байдлын мэдээг иргэдэд цахимаар хүргэж байна.
- Ковид-19 халдвараас сэргийлэх 15 төрлийн зөвлөмж болон анхааруулгыг цахимаар иргэдэд хүргэн ажиллаж байна.

Шинэлэг ажил:

- Соёлын төвөөс зохион байгуулж байгаа түүхийн дурсгалт газруудыг шинэчлэн янзлах ажлын хүрээнд манай байгууллагад хариуцуулсан Мандалын хонхор шүүтийн 1,2-р хүн чулуун хөргийг очиж үзэж хэрхэн янзлах талаар ажилчдын хамтаар ярилцан чулуун хөрөгний хашааг шинэчилж, нэг чулуун хөрөгний хашааг нь сэлбэн янзалж будалж гагнасан. Энэ ажил одоогийн байдлаар дуусаагүй байна.

- 2021.10.01 Ахмадын баяраар байгууллагаас тэтгэвэрт гарсан 12 ахмадуудад байгууллагын төсвөөс гарын бэлэг өгч хүндэтгэл үзүүлсэн. /Гарын үсэг зуруулсан./

Санхүү:

Нийгмийн даатгалын тайланг 9 сарын 30-ны дотор гаргаж нийгмийн даатгалын байцаагчаар баталгаажуулан илгээсэн.

Шилэн дансанд сар бүр оруулах хэсэгт-3, тухай бүр оруулах хэсэгт-8, улирал бүрт оруулах хэсэгт-1 мэдээлэл нийт 12 мэдээллийг хугацаанд нь оруулсан байна. Мөн шилэн дансны 3-р улирлын тайланг хийж илгээсэн.

Татварын 3-р улирлын тайлан цалин хөлс, суутган төлөгч тус бүрээр нь хийж хуулийн хугацаанд илгээсэн.

Санхүүгийн 3-р улирлын тайланг хийж Е-тайланд шивж оруулсан. Няраваас хүнсний 7,8,9-р сарын тайланг авч санхүүгийн программд шивсэн. Мөн шатахуун, сэлбэг, эм эмнэлэгийн хэрэгслийн тайлангуудыг шивж өр авлагын журналыг хааж ажилласан. 2020 оны санхүүгийн баримтуудыг тулган үзэж баримтыг үдсэн.

Мал эмнэлгийн чиглэлээр

Хөрш зэргэлдээ сумдад малын гоц халдварт үхрийн арьс товруутах өвчний сэжиг илэрч үүнтэй холбогдуулан малчдад сэрэмжлүүлэг мэдээ мэдээллийг facebook болон гарын авлага боршур бэлтгэн хүргэсэн. Мөн багийн дарга нар багийн айл өрхүүдэд утсаар мэдээлэл өгч ажилласан. Мөн засаг дарга хувийн мал эмнэлгийн эмч нарт үүрэг чиглэл өгсөн. Мэдээллийн дагуу шуурхай арга хэмжээ авч малчид үхэр сүргээ шүршиж угаах ажлыг 2021.10.06-ны өдрөөс эхлэн хийж эхэлсэн. Нийт 13 өрхийн 1087 үхэр угаалгад хамрагдсан байна

Жил бүр хийгддэг лабораторийн шинжилгээнд хээлтүүлэгч малыг хамруулах ажлыг зохион байгуулж ажиллаа. Энэхүү ажил хувийн мал эмнэлгийн эмч, тамгын газрын ажилчид хамтран хийж гүйцэтгэсэн. Нийт 220 ухна, 392 хуцаас бруцеллөз өвчний тандалтыг хийж дээж авч аймгийн мал эмнэлгийн газарт ийлдсийг ялган хүргүүлсэн

Мал эмнэлгийн цахим системд урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлийг оруулж ажилласан. Үүнд: бруцеллөз, дуут, боом гэх мэт тарилгын гүйцэтгэлийг бүрэн оруулж ажилласан.

2021.10.04-ны өдөр 1-р багийн малын эмч Ц.Энхмаа 215 хээлтүүлэгчээс бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалтын цусны дээж авч ажилласан. Ийлсийг ялган аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлсэн болно

2021.10.08-нд МЭТ-ийн тархварзүйч Г.Сугар 1-р багийн дарга С.Сугар, 2-р багийн дарга Ц.Төмөрсүх, Хүн ам зүй НБХ мэргэжилтэн П.Эрдэнэ, Галч Ганбаяр нар хамтарч 2-р багийн 397 хээлтүүлэгч малаас цусны дээж авч ажилласан. 2021.10.11-нд ийлдсийг ялган авч дагалдах материалуудын хамт аймгийн мал эмнэлгийн лабораторт хүргүүлж ажилласан.

Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажил явагдаж гүйцэтгэлийг цахим системд бүрэн оруулж дагалдах материалыг аймгийн мал эмнэлгийн газар хүргүүлсэн

Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

2021 оны 10-р сард албан хэрэг хөтлөлтийн явцад зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийг бүрдүүлж, зааврын дагуу хөтөлж, дээд газраас ирж буй албан бичиг эрхийн актыг хүлээн авч, бүртгэн удирдах албан тушаалтанд танилцуулж, холбогдох албан тушаалтанд

шийдвэрлүүлэхээр шилжүүлж, шийдвэрлэлтийн хугацаа, биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа.

-10-р сарын байдлаар дээд газраас 19 нийт албан бичиг ирснээс, хариутай бичиг 6 ирж, 3 албан бичгийн хариуг хугацаанд нь барагдуулж, хугацаа болоогүй 3, албан бичиг байна.

-Мөн 10 сарын байдлаар нийт 6 эрх зүйн баримт бичиг ирснээс Аймгийн Засаг даргын Захирамж – 5, Аймгийн ИТХ-ын Тогтоол 1 ирж хэрэгжиж байна.

-Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж хугацаатай бичгийн жагсаалтыг гаргаж дотоод чатад тавьж мэдээлж ажиллаж байна.

Дотоодын ажлын талаар:

2021 оны 10-р сарын байдлаар;

1.Сумын Засаг даргын А-Захирамж - 10

2.Сумын Засаг даргын Б-Захирамж - 3

4.Засаг даргын албан бичиг -4

5.ЗДТГ-ын даргын А-Тушаал - 3

6.ЗДТГ-ын даргын Б-Тушаал - 0

7.ЗДТГ-ын даргын албан бичиг -4

Нийт 3 албан бичгийг хүргүүлж ажилласан.

Өргөдөл гомдлын талаар:

2021 оны 10-р сарын байдлаар иргэдээс Засаг дарга болон Тамгын газрын дарга, холбогдох албан тушаалтнуудад хандаж 0 өргөдөл гомдол ирж шийдвэрлэгдсэн.

Архивын ажлын талаар:

2020 оны хөтлөгдөж дууссан хэргийг эмхлэн цэгцэлж, нэр төрлөөр ангилан төрөлжүүлж хадгаламжийн нэгж бүрдүүлэн ажиллаж байна.

Egr-mongolia ажлын талаар:

Egr-mongolia системд өдөр бүр нэвтэрч мэдээлэл солилцож байна.

Бусад ажил

Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын өрөөнүүдийг хаягжуулсан

Улсын бүртгэлийн чиглэлээр

Иргэний бүртгэлийн үйлчилгээг иргэний хүсэлтийн дагуу тасралтгүй хүргэн ажиллаж байна.

Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл Үүнд:

-Төрсний бүртгэл-5

-Үрчилсэний бүртгэл-1

-Гэрлэлтийн бүртгэл -2

-Нас барсан-1

Иргэний цахим үнэмлэх олголт

-Иргэний үнэмлэх захиалга ИУБ31-6 иргэн

-Иргэний үнэмлэх олголтын бүртгэл-4 иргэн

-Иргэний үнэмлэхний лавлагаа албан хэрэгцээнд -13

-Гэрлэлт бүртгэлгүй лавлагаа албан хэрэгцээнд -4

-Гэрлэсний лавлагаа албан хэрэгцээнд -5

-Төрсний лавлагаа албан хэрэгцээнд – 1

Иргэний шилжилт хөдөлгөөн

-Сум хооронд шилжиж ирсэн насанд хүрсэн -1

гэх мэт иргэний бүртгэлийг холбогдох бичиг баримтыг хүлээн авч хүсэлтийн дагуу

шийдвэрлэж ИУБ хаадар маягтуудыг Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлж ажиллалаа.

Улсын бүртгэлийн хэлтэст сар бүрийн 25-нд үнэт цаас ,үйл ажиллагааны тайлан мэдээг тогтмол цаг хугацаанд хүргүүлж байна.

Мөн аймаг, хот, сум, дүүрэг, баг хооронд, иргэний үнэмлэх олголт үрчлэлт ,гэрлэлт, шинэ төрсөн, зэрэг журналуудыг хөтлөж байна.

2021. 09 сарын 24-нд www.civil.mn шинэ систем программ суулгаж иргэдийг бүртгэж байна

10 сарын 11-ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газарт Үрчилсэний бүртгэл, Гэрлэлт дуусгавар болсны бүртгэлийн мэдээллийг цуглуулж онлайнаар мэдээлэл өгч ажилласан.

10 сарын 15ны 10 цагт Авилгалын эсрэг,14 цагт Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ,гэр бүлийн хүчирхийлэл,хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цахим онлайн сургалтанд хамрагдсан.

Бусад:Ойрын хавьтлын тандалтын мэдээг 2021.10.14-10.20-ний хооронд мэдээллэж өгсөн.

Нийгмийн бодлогын чиглэлээр

Наран сумын хамтарсан баг нь гэр бүл дэх хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа , гэр бүлийн зөрчлийг илрүүлэх , эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн нөхцөл байдал , хэрэгцээг тодорхойлох түргэвчилсэн үнэлгээ хийж, нэн шаардлагатай тусламж дэмжлэг , үйлчилгээ үзүүлэх эцэг эх асран хамгаалагчийн хүүхдэд тавих анхаарал халамж, хараа хяналт, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулах, иргэдийг сонсох , гэр бүлийн боловсрол олгох, Ковид-19 халдварт цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмж өгөх зорилгоор туршилтын хөтөлбөрийн нийт өрх, тандалт судалгаа хийж кеис үйлчилгээний өрх, архины хамааралтай өрхүүд, тандалт судалгааны өрхүүдээр 2 баг болон хуваагдаж 230 км явсан. болон нийт 35 өрхөөр урьдчилсан сэргийлэх зөвлөгөө зөвлөмж өгөх болон кейсийн үйлчилгээний ажил цэцэрлэг сургуулийн холын хүүхдүүддээ хичээлийн даалгаварыг өгч нийт 400 мянган төгрөгийг зарцуулсан.

Улсын хэмжээнд нөхцөл байдал хүндэрч байгаа тул цаг үеийн байдалтай холбогдуулан хариуцлагатай ажиллаж байна.

Мөн хамтарсан баг нь Дэлхийн гар угаах өдөрлөгт зориулсан Гар угаах ач холбогдол сэдэвт гар зургийн уралдаанд СӨБ,ЕБС-ийн хамарсан 3-н насны ангилалд явуулж шагнаж урамшуулсан.

Ковид цар тахалын хүрээнд ГБХЗХГ-т covid 19 цар тахлын онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллын салбар дундын бүлгийн бэлэн байдал, хариу арга хэмжээний тайланг 14 хоногт нэг удаа, хүүхдийн өвчлөлийн мэдээг тухай бүр хүргэж ажиллаж байна. Хамтарсан багийн хуучин самбарийг шинэчилж байна. ХАӨМС-ийн алдааг тухай бүр уншуулж хянаж ажиллаж байна. Ойрын хавьталын тандалтыг 1-р баг дээр хийж байна. Яамнаас болон ГБХЗХГ-аас явуулж байгаа сургалт суртачилгаа подкастыг цаг тухайд нь явуулж байна.

Хуц, Ухнын цусны шинжилгээ авах ажилд МАА-н мэргэжилтнүүдтэй нэг өдөр явсан.

Байгууллагийнхаа бүх өрөөний хаалган дээр хаягжуулалт тогтоон ажиллалаа.

Хамт олноороо Албан байгууллага аж ахуйн нэгжийн газаруудад 324000 төгрөгөөр 12 ш хулдаасан самбар авч байрлуулж ажиллалаа.

Хөдөлмөр эрхлэлт,халамж үйлчилгээний чиглэлээр

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:Аймгийн үзэсгэлэн худалдаанд төсөл хөтөлбөрт хамрагдсан 4 иргэнийг амжилттай оролцуулсан.

10 дугаар сарын 28-нд суманд болох үзэсгэлэн худалдаанд төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийг оролцуулахаар зарыг хүргэн бэлтгэл ажлыг хангуулсан.

Залуучуудын хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийн дадлага дууссан залуучуудад мэдээлэл өгөн материалыг хүлээн аваад байна.

10 дугаар сарын 14-нд ХХҮГ-ын мэргэжилтэн ирж эргэн төлөлтийн хугацаа хэтрэлттэй 4 иргэнд мэдэгдэх хуудас өгөн ажилласан.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 1 иргэний төсөлд хяналт хийсэн.

Шинээр -10 ,ажил зуучлалаар- 2 иргэнийг LIMS праграммд бүртгэсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр:Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийж асаргаа сунгуулах 1 иргэний,ОНОТХҮ-ий 2 төсөл,түлээний хөнгөлөлт авах 3 иргэний асуудлыг хэлэлцсэн.

09 дүгээр сарын 27-нд зорилтот 2 өрх хүнсний ногоогоо хураанд авсан.Нийт 300 кг төмс,20 багц сонгино хураан авч өөрсдийн хэрэгцээнээс илүүг зарж борлуулж өрхийн орлогоо нэмэгдүүлсэн.

10 дугаар сарын 13-нд хүнсний эрхийн бичиг үйлчилгээнд хамрагдаж буй өрхүүдэд шинэчилсэн журмын талаар мэдээлэл хийсэн.

Халамжаас хөдөлмөрт зорилтын хүрээнд 10 дугаар сарын 14-нд аймгийн ХХҮГ-аас дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг ирж хүнсний эрхийн бичиг үйлчилгээнд хамрагдаж буй 10 өрхтэй уулзалт хийн 2 өрхийг ОНОТХҮ-ий төсөлд,1 өрхийг 2022 онд малжуулах хөтөлбөрт хамруулахаар болсон.10 өрх хүнсний эрхийн бичиг үйлчилгээнээс татгалзах саналтай байгаагаа илэрхийлсэн.

10 дугаар сарын 1-нд Олон улсын ахмадын баярыг тохиолдуулан Засаг даргын нөөц сан,зорилтот өрхийн төсвөөс зорилтот бүлгийн 20 ахмадад 600000 төгрөгийн гарын бэлгийг гардуулсан.Мөн албан газрууд ахмадууддаа хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулсан.

Сард үйлчилгээ үзүүлж байгаа иргэдээ нас,хүйс,боловсрол,үйлчилгээ авсан төрлөөр нь дэлгэрэнгүй бүртгэл хөтлөн ажиллаж байна. Үүний дагуу 10 сарын 22-ны байдлаар 212 хүнд 18 чиглэлээр мэдээлэл өгөн ажилласан байна

Хөдөө аж ахуйн чиглэлээр

Монгол улсад орчин цагийн худалдааны салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Малчид,үйлдвэрлэл,үйлчилгээ эрхлэгчийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн,үйлчилгээ,мэдээллийг олон нийтэд танилцуулах,үйл ажиллагааг нь дэмжин хөгжүүлэх,харилцан туршлага солилцуулах зорилгоор “Намрын ногоон өдрүүд-,Сүхбаатарт үйлдвэрлэв-2021 үзэсгэлэн худалдаа 12 дахь жилдээ 2021 оны 10 дугаар сарын 08-09 ны өдрүүдэд Баруун-урт хотод зохион байгуулагдлаа.Уг арга хэмжээнд 12 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай сайн оролцоод ирлээ.

-Шилдэг гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч-2-р байр - Б.Сарантуяа

-Шилдэг оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгч -2-р байр - Б.Янжмаа

Монголд улсад орчин цагийн худалдааны салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг улс орон даяар өргөн тэмдэглэх Монгол улсын Засгийн газрын тогтоол гарсны дагуу Сүхбаатар аймагт 2021 оны 10 дугаар сарын 08-09-ний өдүүдэд зохион байгуулагдлаа.Энэхүү арга хэмжээнд худалдааны 100 жилийн ойн тэмдэгээр 3 иргэн шагнагдсан байна.

-Худалдааны салбар-Л.Билгээ

-Нийтийн хоол

үйлдвэрлэл,үйлчилгээний салбар -Б.Сарантуяа

-Ахуйн үйлчилгээний салбар-Д.Оджаргал нар тус тус шагнагдсан байна.

Сум хөгжүүлэх сангаас зээл аваад төсөл хэрэгжих хугацаа дууссан зээлдэгч нартаа мэдэгдэх хуудас өгч 2021.10.25-ны дотор төлж барагдуулахыг мэдэгдэж заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд шүүхийн байгууллагад хандахыг мэдэгдэж ажиллалаа.

Мөн намрын ангилалт болон ээмэгжүүлэлт цаг үеийн технологит ажлууд хийгдэж байна .

Төсөв,төрийн сангийн чиглэлээр

Төсөвт байгууллагуудын 10 сарын цалингийн гүйлгээ болон цалингаас бусад гүйлгээнүүдийг анхан шатны баримтыг үндэслэн хийж байна.

10

сарын статистикийн улирлын мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.

ААНэгж, айл өрхүүдийн халаалтыг 10 дугаар сараас өгч эхлэх учир уурын зуухны халаалтын гэрээг төлөвлөж бэлтгэсэн.ЗДТГ-ын ажилчдын хуралд тогтмол сууж хийсэн үүрэг даалгавар болон хийгдэх ажлын талаар ярилцан санал бодлоо солилцож байна.Төрийн сангийн санхүүгийн нэгдсэн системд төсөвт байгууллагын баталгаажуулах албан тушаалтан буюу дарга,эрхлэгч, нябо нарыг бүртгэж дуусгалаа Сангийн яамнаас төрийн сангийн мэргэжилтэнгүүдэд Эрхийн бүртгэлийн сангийн талаарх сургалт хийлээ.

